

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 01 сарын 29-ны өдөр

Дугаар БА-037/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянзүрх дүүргийн 42 дугаар хороонд, баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 12 давхар, 1 блок, 10 (арав) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 115 (нэг зуун арван тав) айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 11 сарын 15-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 0014264 огноо 2023/11/30, дугаар БАЗГ2023/969
- 2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: ХО-21/04
- 2.3. Захиалагч: Иргэн Б.Болдбаатар, регистрийн дугаар: ПИ71040115, Хаяг: Баянзүрх дүүрэг 14-р хороо, консул 13 гудамж 332/б тоот, холбоо барих утас: 99118807 цахим хаяг: ,
- 2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: “Их бодь Констракшн” ХХК оноосон нэр: 9011706091, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 000153696, регистрийн дугаар: 6244904 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: БУ12-2019/17, Хаяг: Баянзүрх, 14-р хороо, 123Б байр холбоо барих утас: 88046981 цахим хаяг: Odgerel@ikhbodi.mn
- 2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: “Их бодь Констракшн” ХХК оноосон нэр: 9011706091, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 000153696, регистрийн дугаар: 6244904 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: БУ12-2019/17, Хаяг: Баянзүрх, 14-р хороо, 123Б байр холбоо барих утас: 88046981 цахим хаяг: Odgerel@ikhbodi.mn
- 2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “Татбос” ХХК, оноосон нэр: 9011093005 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: регистрийн дугаар: 5124859, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар ЗТ12/606/22 Хаяг: Баянзүрх дүүрэг 6-р хороо, 13-р хороолол, 21-157 тоот холбоо барих утас: 88002824, цахим:

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага:

Өмчлөгч: “Их бодь Констракшн” ХХК оноосон нэр: 9011706091, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 000153696, регистрийн дугаар: 6244904 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: БУ12-2019/17, Хаяг: Баянзүрх, 14-р хороо, 123Б байр холбоо барих утас: 88046981 цахим хаяг: Odgerel@ikhbodi.mn

Ашиглагч: “Хүрд” ХК оноосон нэр, 9010001054 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистрийн дугаар 2061783, Хот суурин усан хангамж ариутгах татурга ашиглат үйлчилгээ зохицуулах хороо дугаар 00398, Эрчим хүчний зохицуулах хороо 2028/2012 27/2012 Хаяг: Баянзүрх дүүзэг 42-р хороо, 31 гудамж, холбоо барих утас: 99795610 цахим хаяг: Khurdcompany@gmail.com

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 12 давхар, 1 блок, 10 (арав) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 115 (нэг зуун арван тав) айлын орон сууцны зориулалттай барилгын байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад 7 хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа

ХЯНАЛТ ША.
ГАЗА
Барилга байгууламж
орлуулах к

дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3 Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох 1 хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 12 давхар, 1 блок, 10 (арав) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 115 (нэг зуун арван тав) айлын орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Баянзүрх дүүргийн 42 хороо Иргэн Б.Болдбаатар захиалгатай, зорьтой 12 давхар, 1 блок, 10 (арав) автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 115 (нэг зуун арван тав) айлын орон сууцны барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч




(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга: Иргэн

(Б.Болдбаатар)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 42 ДУГААР ХОРОО, ИРГЭН Б.БОЛДБААТАРЫН
ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 12 ДАВХАР, 1 БЛОК, 10 АВТОМАШИНЫ ДУЛААН
ЗОГСООЛТОЙ, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ 115 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ ЗОРИУЛАЛТТАЙ
БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 11 дугаар сарын 15

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 42 дугаар хороо, иргэн Б.Болдбаатарын захиалгатай, зоорьтой 12 давхар, 1 блок, 10 автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 115 айлын орон сууцны зориулалттай барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгыг ашиглалтанд оруулах комисс 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 10 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 12 цагт дуусав.

Хуралд:

- | | |
|---|----------------|
| 1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга | О.Оджаргал |
| 2. Комиссын нарийн бичгийн дарга: Захиалагч | Б.Болдбаатар |
| 3. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс Барилга техникийн хяналтын улсын /ахлах/ байцаагч | Г.Батбаатар |
| 4. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч | Э.Цогзолмаа |
| 5. Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК | Б.Оргил |
| 6. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер | Ц.Билигт |
| 7. Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК | М.Жаргалан |
| 8. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер | Б.Жамбалцанжид |
| 9. Онцгой байдлын ерөнхий газар /Нийслэлийн Онцгой байдлыг газар / | Б.Мягмаржав |
| 10. Үндэсний Төв Архив | Н.Өлзийжаргал |
| 11. Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн | О.Ундрах |
| 12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, төлөөлөл | Б.Даваасүрэн |
| 13. Ашиглалт хариуцах байгууллага Хүрд ХХК | М.Бямбадорж |
| 14. Зураг төсөл зохиогч байгууллага Татбос ХХК | Б.Баяртогтох |
| 15. Барилгын ажил гүйцэтгэгч Их Бодь Констракшн ХХК | Ц.Одгэрэл |

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан - 15
- Хүрэлцэн ирсэн -15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 42 дугаар хороо, иргэн Б.Болдбаатарын захиалгатай, зoorьтой 12 давхар, 1 блок, 10 автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 115 айлын орон сууцны зориулалттай, барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөв, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын Улсын /ахлах/ байцаагч

Г.Батбаатар

- Барилгад хэрэглэсэн бетоны шинжилгээг үе шат бүрээр нь үзүүлэх. Бетоны лабораторын шинжилгээг үзүүлэх
- Барилгад хэрэглэсэн арматурын шинжилгээг үзүүлэх.
- Тэг тэнхлэг геодизийн дүгнэлт үзүүлэх
- Лифтийг магадлалд оруулсан дүгнэлт зөвшөөрөл үзүүлэх
- Дээврийн давхрын ус зайлуулах хоолойг доош нь буулгах
- Техникийн давхрын зураг төслийг өөрчилж, Гүйцэтгэсэн гүйцэтгэлийн зурагт үзүүлэн тайлбарлах.
- Зураг төслөөр 1 өрөөг БНБД 31-01-10-д дагуу төлөвлөөгүй. Үүнийг тайлбарлах
- Айлын тагтны хаалт хамгаалалт хийх.
- Тагтны тусгаарлахыг галд тэсвэртэй материалаар хийх.
- Зураг төсөл өөрчилж 7-10 айлыг дуплекс хийсэн дээр тайлбар. Гүйцэтгэлийн зураг үзүүлэх.
- Тагтны шилийг ХЭАБ хэмжигч хийлгэх.
- Зураг төслийн байгууллагын эрх зүйн баримт бичгийг үзүүлэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Барилгы стандарт, барилгын аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа**

- Гадна дулааны худгийг цэвэрлэж, дулаалга хийж гүйцэтгэлийг дуусгах.
- Шугамын дулаалгыг дахин солих
- Өөрчлөлтийн зургийг дахин шалгуулах (узель, шугам сүлжээ)
- Узелийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг хаягжуулах
- 1 давхрын үйлчилгээний агааржуулалтын угсралтын баталгаа албан тоот ирүүлэх
- Гадна шугамын зураг, угсралтын ил далд акт шалгуулах
- Дотор халаалт, шугам сүлжээний угсралтын акт шалгуулах
- Халаах хэрэгслүүд дээр термостат суурьлуулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-ийн инженер **О.Ундрах**

- Техникийн давхрын дээврийн усны буултыг дээврээс дээш 30см хүртэл буулгах.



- Тагтанд зургийн дагуу хамгаалалтын төмөр хашлага хаалт хийх
- Шатны хонгилын 1-р давхрын хаалгыг гол орц гарц руу онгойхоор зөв онгойлттой болгож засах
- 7 болон 10-р давхрын хучилтын нүх цоолсон түүнтэй холбоотой арматурчлал дээр ямар арга хэмжээ авсан талаарх тайлбар, албан бичиг ирүүлж, зохиогчийн нэгдсэн дүгнэлтэд тусгаж акт фото зураг ирүүлэх.
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу норм, нормативын төлбөрийг тооцуулж төлөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн инженер **М.Жаргалан**

- Гадна холбооны шинээр хийгдсэн крантын усыг соруулах.
- ХД гүйцэтгэгч зарлан мэдээлэх систем (ПК145-06/21) суурьлуулаагүй талаар тайлбар албан бичиг өгөх
- Давхрын самбарын кабелиудыг бирк хийх
- Зоорийн давхарт орцны өмнөөс харуулан байрлуулсан камерыг үзэгдэх орчинд доошлуулан суурьлуулж фото зургаар баталгаажуулах
- Дутуу суурилуулсан хяналтын камерыг бүрэн суурьлуулах.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

УС сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн менежер **Б.Жамбалцанжид**

- Гадна цэвэр бохир усны ажлын зургийн өөрчлөлтийн зургийг хийлгэж зөвшилцөх
- Ил далд ажлын актыг бүрдүүлж баталгаажуулах
- Т.Нөхцөлийн дагуу гадна цэвэр усны худагт галын гидрант суурьлуулах
- Хүрд ХК-аас холболт хийхийг зөвшөөрсөн албан бичиг шалгуулах
- Цэвэр усны огтолгооны хаалтыг зедвилкан хаалтаар солих
- Усны тоолуурыг баталгаажуулах
- Усны нөөцийн саванд халдваржуулалт хийлгэсэн баримт болон усны шинжилгээ хийлгэсэн дүгнэлт хийлгэх
- Гадна цэвэр, бохир усны шугамын гүйцэтгэлийн үураг шалгуулах, хотын мэдээллийн санд өгсөн актыг шалгуулах
- Бохир усны гаргалгаа худгийн ажлын талбай, хийц, шугамыг засаж сайжруулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчдийн холболтын хэлтсийн дарга **Б.Оргил**

- Гадна дулааны шугамын дулаалга солих, 150 градус бүхий техникийн шаардлага хангасан дулаалга байх.
- Дулааны узелүүдийг хэмжих хэрэгслүүдийг гүйцээж угсрах, нүх хэсгийг бөглөх, байгаануудыг нь хийх, тоног төхөөрөмж шугам хаягжуулах

- Техник ашиглалтын дүрмийн дагуу өгөх, буцах шугам, ХХУ, шугамын өнгөнүүдийг ялгах.
- Далд ажлын акт, нягтын шахалт, угсралтын акт, гэрээ зураг бүрдүүлэх (гадна дулаан, узель дотор, систем)
- Гадна дулаан, Дулаан механик 2-н зургийг өөрчлөлт хийж баталгаажуулах.
- УБДС ТӨХК-д үүрэг даалгаврын биелэлтийг албан тоотоор өгөх
- Угсралт хийсэн компанийн тусгай зөвшөөрөл шалгуулах.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Б. Мягмаржав

- 1-р давхрыг Б1 давхартай холбосон шатны хонгилын өмнө даралттай, агаар үүсгэгчтэй гонх хаалт хийх
- Гадна дулаалга материал галд тэсвэрийн зэрэг шалгуулсан дүгнэлт үзүүлэх.
- Орон сууцны L, Z, H, B айлын тагтны тусгаарлах хаалтыг норм, зураг төсөлд тусгагдсаны дагуу засварлах.
- Тагтны аваарын шатыг нормыг дагуу засварлах.
- Орон сууцны 10, 11-р давхрын D сууц өөрчлөлт хийгдсэн.
- Техникийн давхрын L3 L4 тэнхлэг дагуу өргөтгөл хийгдсэн.
- Галын дохиоллын систем, Гал түймрийн үеийн утаа зайлуулах, агаар өгөх систем хийж гүйцэтгэсэн. Хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл ил далд ажлын акт үзүүлэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага **Б.Даваасүрэн**

- ХБИ-н авто зогсоолын өргөн байгааг стандарт болгох
- Рамнуудыг барилгын 4 буланд налуу замуудын харалдаа хийнэ. Стандартын дагуу
- Цахилгаан шатанд зарлан мэдээллэгч буюу давхар зарлагч суурьлуулах
- Орцны хаалганы онгойлолтыг налуу замын орох хэсгийн эсрэг талруу онгойлгох
- Үйлчилгээний төвүүдийн ХБИ, Өндөх настангуудад зориулсан тусгай тоноглолыг бүх АЦӨ-дэд гүйцээж хийх, Угаалтуурыг тоноглох.
- В1 давхар руу ХБИ хэрхэн зорчих вэ? Зохиогч тайлбар бичиг өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер

Ц.Билигт

- Цахилгааны өрөөний хаалганд хаяг, палкад хийх.
- Орол кабель шугаманд хаалт хийх
- Ерөнхий самбарын их биед хүрээ газардуулга холбох
- Үйлчилгээний хэсгийн тоолуурыг лацдуулах
- Цахилгааны самбарт О утсанд төгсөвч хийх. (айл өрх, үйлчилгээ)
- 2026/08/29-ний өдрийн техникийн нөхцөлийн 3.3 дах заалт, 5.5 дах заалтыг хэрэгжүүлэх.
- В1 болон 1-р давхрын хүчит төхөөрөмжийн гүйцэтгэлийн зураг үзүүлэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна.

Үндэсний төв архивын газар, Зураг төслийн баримтын ахлах архивч
Н.Өлзийжаргал

- Барилга угсралтын ил далд ажлын акт, гэрэл зургийг бүрэн бүрдүүлэх
- Материалын сертификатыг жагсаалтын дагуу нөхөж бүрдүүлэх
- Баримт бичгийн хуудас дугаарлаж, дотоод товъёг үйлдэх, баримтын эх хувийг архивд хүлээлгэн өгөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд авах саналтай байна.

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О. Оджаргал**


- БНБД 11-04-16 дагуу зохиогч дүгнэлт бичих шаардлагатай
- БТХ-ийн дагуу Барилгад чанарын баталгаа гаргаж албан тоотоор ирүүлэх
- Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу 1 орц гарцтай зургийн дагуу гадна тохижилтын ажил гүйцэтгэх шаардлагатай
- Тагтны шилэн хаалтанд металл хамгаалалт хийж гүйцэтгэх
- Тагтны шилэн хаалт хамгаалалт гэрэлтүүлгийг маш ихээр бууруулж байгааг засварлах
- А, В, L, Z айлын м2 норм хангаж байгаа эсэхэд тайлбар албан тоот ирүүлэх
- Шатны хонгилын шатны бариулыг зургийн дагуу гүйцэтгэх
- Барилгын хүчин чадлыг батлагдсан зургийн дагуу тогтоох. (айл, өрх, зогсоол, бусад дуплекс)
- Айл өрхийн гадна хаалга мөргөлдөж байгаад зохиогч албан тоот ирүүлэх
- Тагтны аваарын шат, гарцыг нормд нийцүүлж засварлах
- Зураг төслийн зохиогчтой холбоотой бүх баримт бичгийг хамруулах

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 42 дугаар хороо, иргэн Б.Болдбаатарын захиалгатай, зорьтой 12 давхар, 1 блок, 10 автомашины дулаан зогсоолтой, үйлчилгээтэй 115 айлын орон сууцны зориулалттай барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:
Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:
Захиалагч иргэн

(Б.Болдбаатар)

